



## Нэрийн тэмдэггүй номлогч

Керсти Аравэ

Сургууль дээр маань ямар ч хүн Саливаа сэдвээр санал зөрөлдөхөөс айдаг, тийм зан ааштай нэгэн багш байсан юм. Нэг өдөр бид ХҮГ номлогчдын тухай ярихад би түүний асуултад хариулж чадах байсан ч тэгэх хэрэггүй гэдгийг мэдэрсэн юм. Тиймээс би түүний сэтгэлд нийцүүлэн хариуллаа.

Дараачийн хэдэн долоо хоногт би бидний хооронд өрнөсөн энэ ярианы талаар бодохгүй байж чадсангүй. Эцэст нь номлолын ажлын тухай хэдэн

**Түүнд Мормоны Ном өгөх хэрэгтэй гэсэн бодол төрөв.**

эшлэлийг тодотгож тэмдэглэсэн Мормоны Номыг түүнд өгөх хэрэгтэй гэсэн бодол надад төрөв. Энэ бодол намайг айлгаж байсан ч санаанаас гарахгүй байлаа. Энэ нь дагах ёстой өдөөлт гэдгийг би мэдэж байсан юм.

Хоёр сар гаруйн дараа би Мормоны Номыг бэлэн болгов. Бүх л өдрийн турш уг номыг үүргэвчнээсээ гаргаад өгчихмөөр санагдаад байв.



Санаануудыг  
[ids.org/6176](https://ids.org/6176).  
#Futuremissionary-оос  
үзнэ үү.

Өвлийн амралтаа авахаар явахдаа энэ номыг түүнд өгөхөд шаардагдсан гурван секунд амьдралын минь хамгийн түгшүүртэй үе байлаа.

Амралтын дараах эхний өдөр би түүний ангийн хажуугаар өнгөрсөн ч орохоосоо айсан. Тэгтэл тэр намайг дуудаж, нэгэн карт өглөө. Би үүнийг коридорт уншив. Тэрээр миний тодотгосон хэсгүүдийг бүгдийг нь уншсанаа мөн миний итгэл бишрэлийн цаадах учир шалтгааныг харж эхэлж байгаа бичсэн байлаа.

Би одоо сайн мэдээг хуваалцана гэхээс догдолдог болсон. Би удахгүй Тэнгэрлэг Эцэгтэй үйлчлэхээр номлолд явахыг илүү их сэтгэл догдлон хүлээж байна.

*Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.*

## ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

### Номлолын үйлчлэл

Номлогчид сайн мэдээг зааж, бусдад үйлчлэхээр дуудагддаг. Зурагт нуугдсан эдгээр хэрэгслийг олоход номлогчдод туслаарай.

